



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар

A/488

Номгон

“Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 29.2, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны “Тарвагыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг түр хугацаагаар хориглох тухай” А/193 дугаар тушаал, аймгийн “Онцгой комиссын ажиллах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.6 дах заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт зоонозын халдварт тарваган тахал өвчний халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2021 оны 08 дугаар сарын 09-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл тарвагны мах, түүнтэй холбогдох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцож ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), сумдын Засаг дарга нарт.


2.Холбогдох мэргэжлийн байгууллагын алба хаагчдыг тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамруулж урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төв (С.Баасанхүү)-д, захирамжийн хэрэгжилтийг хангаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан олон нийтэд хүргэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Л.Баянмөнх) нарт тус тус үүрэг болгосугай.


3.“Хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ыг нэгдүгээр, Хяналтын байр, ажиллах бүрэлдэхүүний хуваарийг хоёрдугаар, Хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг гуравдугаар, шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

601210115

4. Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах 7,214,300 (долоон сая хоёр зуун дөрвөн мянга гурван зуун ) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



The stamp is rectangular and contains the following text: "БАНКНУМ" (Bank) at the top, "Хүндэтгэсэн" (Authorized) in the middle, and "Д.Мөнхсайхан" (D. Mönkhсайхан) at the bottom. The signature is written over the stamp.



## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОН ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нь удирдамж нь Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт тарваган тахал өвчний халдвар гархаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад оршино.

### Хоёр. Үйл ажиллагааны чиглэл

2.1. Тарваган тахал өвчний халдвар зөөгдөн орж ирэхээс урьдчилан сэргийлж, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах байнгын хөдөлгөөнт цэгийг тогтоож, дараах байдлаар ажиллуулна.

Үүнд: 1. Урд хэсэгт Авто тээврийн шалган бүртгэх товчоо  
2. Баруун хэсэгт Төв зам дагуу автозамын уулзвар  
3. Хойд чиглэл Түйн голын дээд гарам  
4. Баян-Овоо сумын чиглэлийн автозам (10 мянгатын автозамын төгсгөл)

2.2. Орон нутагт хяналт шалгалт хийх хуваарь.

1. Бууцагаан-Хүрээмарал-Баянбулаг-Гурванбулаг-Заг (2021.08.10-2021.08.20)
2. Галуут, Жаргалант, Баян-Овоо (2021.08.20-2021.08.30)
3. Эрдэнэцогт-Шаргалжуут-Өлзийт (2021.09.05-2021.09.16)
4. Зах, худалдааны төвүүд (Тухай бүр)

2.3. Эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Онцгой байдлын газрын Шуурхай удирдлагын төвийн /7044101/ тусгай дугаарын утсанд мэдээлнэ.

2.4. Хяналтын хөдөлгөөнт эргүүлийг хариуцаж байгаа байгууллага 7 хоног бүрийн "Даваа" гарагт шалгалтын дүнг илтгэх хуудсаар Онцгой байдлын газарт танилцуулна.

2.5. Сумдууд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд тарваганы мах, түүхий эд, дайвар бүтээгдэхүүн оруулахыг хориглох, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах, иргэдэд сэрэмжлүүлэх мэдээ, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

2.6. Хяналтын байнгын цэгүүдээр нэвтрэн өнгөрөх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, зорчигчдын ачаа тээшинд үзлэг шалгалт хийх, тарваганы арьс, түүхий эд илэрсэн тохиолдолд хураан авч, Зоонозын өвчин судлалын төвд хүлээлгэн өгч, устгуулах, автомашин, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу халдваргүйжүүлнэ.

Гурав. Ажиллах бүрэлдэхүүний эрх үүрэг

3.1. Хяналтын байршлуудад Мэргэжлийн хяналтын газраас томилогдсон алба хаагч ахлагч ажиллана.

3.2. Зөрчил илэрсэн иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлнэ.

3.3. Хэсгийн ахлагч нь удирдлагад ажиллаж байгаа ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.4. Цагдаагийн алба хаагч нь авто техникийн шалган бүртгэх товчоонуудаар дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийг зогсоож, үзлэгт оруулах, хэв журмыг сахиулах, үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангана.

3.5. Зоонозын өвчин судлалын төвийн эмч, мэргэжилтэн ариутгагч нар халдваргүйжүүлэлт хийгдээгүй тарваганы арьс, түүхий эд материал хураан авах, устгалд оруулах, халдваргүйжүүлэх бөгөөд саатуулагдсан иргэдийн ачаа тээш, машин техник хэрэгслийг ариутгаж халдваргүйжүүлнэ.

3.6. Үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүн авто тээврийн шалган бүртгэх товчоогоор дамжин өнгөрөх иргэдэд ухуулга, сурталчилгаа хийх, хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

3.7. Байгаль орчны байцаагч нь тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн хариуцсан хэсэгт хариуцан зохион байгуулна.


Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1. Энэхүү журмын хэрэгжилтэд аймгийн Онцгой байдлын газрын дарга хяналт тавьж ажиллана.

4.2. Энэхүү журмыг зөрсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 05-ны  
өдрийн А/483 захирамжийн хоёрдугаар  
хавсралт




АЙМГИЙН ТӨВД ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛЭЭР АЖИЛЛАХ  
БҮРЭЛДЭХҮҮН

№	Байршил	Чиглүүлэгч байгууллага	Хамтранажиллах бүрэлдэхүүн	Хугацаа
1	Самбартай хөтөл	Мэргэжлийн хяналтын газар	Онцгой байдлын газар-1, Мэргэжлийн хяналтын газар-1, Цагдаагийн газар-1, Зоонозын өвчин судлалын төв-1, Байгаль орчин, аялал жуулчлалын газар-1	VIII/01- VIII/10
2	Урд хэсэгт АТШБ товчоо	Мэргэжлийн хяналтын газар	Онцгой байдлын газар-1, Мэргэжлийн хяналтын газар-1, Цагдаагийн газар-1, Зоонозын өвчин судлалын төв-1, Байгаль орчин, аялал жуулчлалын газар-1	VIII/09- X/15
3	Баруун хэсэгт Төв зам дагуу автозамын уулзвар дээр	Цагдаагийн газар	Онцгой байдлын газар-1, Мэргэжлийн хяналтын газар-1, Цагдаагийн газар-1, Зоонозын өвчин судлалын төв-1, Байгаль орчин, аялал жуулчлалын газар-1	
4	Хойд чиглэл Түйн голын дээд гарам	Онцгой байдлын газар	Онцгой байдлын газар-1, Мэргэжлийн хяналтын газар-1, Цагдаагийн газар-1, Зоонозын өвчин судлалын төв-1, Байгаль орчин, аялал жуулчлалын газар-1	
5	10 мянгатын гарам	Онцгой байдлын газар	Эрэн хайх аврах бүлэг, 2 Гал түймэр унтраах аврах 16 дугаар ангиас 2 алба хаагч	

**Тайлбар:** Аймгийн Онцгой комисс нь нутаг дэвсгэрийнхээ авто техникийн шалган бүртгэх товчоон дээр ажиллаж ажлын хэсгийн үүрэг гүйцэтгэлтэд тогтмол хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 05-ны  
өдрийн А/483 захирамжийн гуравдугаар  
хавсралт



**ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРТГИЛЭХ ХЯНАЛТ,  
ШАЛГАЛТ ХИЙХ ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ**

№	Хариуцан зохион байгуулах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Бууцагаан Хүрээмарал, Баянбулаг Гурванбулаг, Заг /1-р чиглэл, нийт-1000 км/	Галуут, Жаргалант, Баян-Овоо /2-р чиглэл, нийт-700 км/	Эрдэнэцогт, Шаргалжуут, Өлзийт /3-р чиглэл, 660 км/	Баянцагаан, Богд, Баянговь /4-р чиглэл 1140 км/
1	Онцгой байдлын газар	Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Зоонозын өвчин судлалын төв, Байгаль орчин аялал, жуулчлалын газар	VIII/10- VIII/20	-	-	-
2	Мэргэжлийн хяналтын газар	Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Зоонозын өвчин судлалын төв, Байгаль орчин аялал, жуулчлалын газар	-	VIII/20- VIII/30	-	-
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Зоонозын өвчин судлалын төв, Байгаль орчин аялал, жуулчлалын газар	-	-	IX/05-IX/15	-
4	Цагдаагийн газар	Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Зоонозын өвчин судлалын төв, Байгаль орчин аялал, жуулчлалын газар	-	-	-	IX/15- IX/25

**Тайлбар:** Хөдөлгөөнт эргүүлээр тухай тайланг 7 хоног тутамд Онцгой байдлын газарт ирүүлнэ.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 сарын 05-ны  
өдрийн А/483 захирамжийн дөрөвдүгээр  
хавсралт

ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН  
НЭГДСЭН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нийт зардал	Хянасан
1	Урьдчилан сэргийлэх зардал	3,047,600	
2	Устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	1,412,700	
3	Аймгийн төв орчмын эргүүл, хяналт шалгалтын шатахууны зардлын тооцоо	2,754,000	
4	<b>Зардлын нийт төсөв</b>	<b>7,214,300</b>	

-----oO-----